

СҮНЗИЙН СУРГААЛ БА ОРЧИН ҮЕ

Ч.Таамаа - МУИС.ГХСС-ийн Хятад судлалын тэнхмийн профессор
Г.Наранцэцэг - МУИС.ГХСС-ийн Хятад судлалын тэнхмийн магистрант

Түлхүүр үг: соёл, ёс горим, ёслолын ажиллагаа, дайтахуйн ухаан, тулааны идэвхжил

Сүнз нь МЭӨ 313-238 онд амьдарч байсан, Күнзийн сургаалийг баримтлагч гүн ухаантан, төрийн түшмэл хүн юм. Түүний жинхэнэ нэр нь Сюнь Куан. Тэрээр байлдаант улсын дараахи Жоу улс одоогийн Хө Бэй болон Шань Си мужийн өмнөд нутгийн хүн. Тухайн үед Хятад улс түүхийн томоохон өөрчлөлтийн үе болох боолын нийгмийг халж, феодалын нийгмийг бий болгосон цаг үе байлаа. Ийм нөхцөл байдалд тэрээр цагийн урсгалд нийцэн, Хятад улсын нэгдмэл байдлын төлөө улс төрийн хэтийн бодлоготой байсан бөгөөд Жи,Чин,Чү, Жоу улсуудад Сүнз очиж байсан гэдэг. Хамгийн анх Чү улсад очиж, Тэнд Вангийн ёст төрийг бий болгох оролдлого хийж байжээ. Тэгэхдээ Чи мин Ван-д "төрийн хэргийг анхаарахгүй аваас ард түмнийг аюул нөмрөх болно"⁵⁹ хэмээн сануулга өгч байв. Гэвч Чи Мин Ван өөрийн гавъяа, эрдэм чадвартаа эрдэж, Сүнзийн саналыг анхаарч аваагүй байна. Тийнхүү Сүнз Чи улсаас явсны дараа төд удалгүй Чи улс Ян улсад ялагдсан түүхтэй.

Гэвч тухайн үед Сүнз хүн чанар хийгээд эрдэм чадвараараа олны хүндэтгэлийг ихээр татаж байв. Үүнийхээ дараа Жоу улсад очсон хэдий боловч гүжир гүтгэлэгт автан мөн л тухайн улсаас явжээ. Хожим нь Жоу улсын Чүнъ Шань Цүнъ, Сүнзийг Жоу улсад эргэн ирж улс төрийн үзэл онол, цэргийн эрдэм чадвараа түгээхийг гуйсан гэдэг. Ингээд тэрээр Жоу улсад эргэн очиж Лань Лин Линий төрийн албанд хүчин зүтгэсээр өтөл насаа өнгөрөөжээ. Түүний сэтгэлгээний онол Чин улсын эрдэмтэдэд нөлөөлсний ачаар ард түмэн нэгдэх хандлагатай болсон байна. Сүнзийн өвөг дээдэс нь цэргийн сурвалжтан хүмүүс байжээ. Тиймээс хар багаасаа цэрэг дайны хэрэгт дурлан тэр цаг үеийн ёс жаягаар гэрийн сургуулиар цэргийн эрдэм боловсрол олсон ажгуу.

Сүнз өөрөөсөө өмнөх үеийн Хятадын гүн ухааны олон үзэл сургаалыг судалж шүүмжлэн, тэдгээрийн ололттой талуудыг нэгтгэсэн гүн ухааны үзэл боловсруулжээ. Тэрээр хэдийгээр Күнзийн үзлийг баримтлагч байсан боловч зарим дутагдалтай талыг олж харан засч залруулсан байдаг. Күнзийн философи дахь "тэнгэрийн хүсэл зориг" "тяньмин" хэмээх ойлголтыг шүүмжлэн хэлэхдээ: "Тэнгэр нь ид шидтэй эзнийх биш, харин байгалийн үзэгдэл үйл явц юм...". Ертөнцийг бүтээгч гэж байхгүй. Ертөнцийн юм бүхэн өөрийн шалтгаантай, өөрийн хөгжил хөдөлгөөнтэй. Тэнгэр, газар, байгаль, хүн нь өөрийн бодит хуультай. "Одод тойрон эргэж, наран саран ээлжлэн, дөрвөн улирал солигдож, инь ян хоёр үлэмж их өөрчлөлтөөр гарч, салхи, бороо дэлгэрч хамаг юм зохицож, өөрийн амьдралаар амьдарч байдаг"⁶⁰ гэжээ. Эндээс үзвэл, тэрээр философийн үзлийн хувьд материалист үзлийг баримтлагч юм.

⁵⁹ Zhong hua ming zu jie chu ren wu chuan. Beijing. 1984. P. 123

⁶⁰ Фэн Ю Лань. Хятадын философийн товч түүх. УБ., 2003. 132 дахь тал

Цааш нь, “Ертөнцийн аливаа юмс үзэгдэл инь ба яны харилцан үйлчлэл болох цигээс үүссэн. Гэвч ертөнцийн юмс үзэгдэл олон янз байдаг” гээд, “Гал, ус цигээс бүрдэх боловч амьгүй, өвс ургамал амьтай боловч мэдрэхүй байхгүй, араатан жигүүртэн мэдрэхүйтэй боловч оюун ухаан байдаггүй, харин хүн бол цигээс бүрддэг, мэдрэхүй, оюун ухаантайгаараа бүхнээс онцгой”⁶¹ хэмээн өөрийн философийн үзлээ Сүнз илэрхийлжээ.

Түүний философийн гол зарчим нь хувирал өөрчлөлтийн зарчим юм. Энэ талаар тэрээр өгүүлэхдээ: “Таван махбод эсрэгцэн оршихуйд түүний аль нэг нь эс хувиран, илт дангаар ноёлохуй нь үгүй, дөрвөн улирал ээлжлэн хувирахуйд түүний аль нэг нь эс солигдон, илт дангаар оршихуй нь үгүй, гэгээн наран өдөртөө урт ч буй, богино ч буй, гэрэлт саран шөнөдөө тэргэл дүүрэн ч буй, түнэр харанхуй ч буй”⁶² гэжээ. Үнэхээр ертөнцөд өөрчлөгдөхгүй зүйл гэж байхгүй бөгөөд өөрчлөлт бол бүхний оршихуйн үндэс мөн. Эндээс үзвэл бид ч өөрсдийгөө сайн сайхны зүгт байнга өөрчилж шинэчлэгдэж байх хэрэгтэй юм.

Сүнзийн хувьд “Хүн, тэнгэр, газар (дэлхий) нь нэгдмэл чанартай”, бас өөр өөрийн ялгаатайг тэмдэглэсэн буй. “Тэнгэр улиралтай, дэлхий баялагтай, хүн соёлтой”⁶³. Аливаа хүн, нийгэм, “соёлжсон” байх ёстой. Учир нь соёлгүйгээр сайн сайхан амьдрал байж чадахгүй. Соёл бол хүний хоёр дахь төрөлт гэсэн үг ч байдаг. Сүнзийн үзлээр, хүн төрөлх чанараараа хорон муу чанартай байдаг. Хүн төрөлхийн мунхаг, ашиг олзонд шунах, атаа жөтөөч байдаг. Үүнийг засч сайжруулахад хүнд мэдлэг, соёл зайлшгүй хэрэгтэй хэмээн Сүнз үзсэн учир түүний философийг соёлын философи хэмээн нэрлэх ч ёс бий. Түүний гүн ухааны нэг гол баримтлал нь үнэ цэнэтэй, сайн сайхан бүхэн хүний мэдлэг, соёл, хөдөлмөрийн их хүч чармайлтын үр дүн байдаг, тэгэхлээр соёл бол хүний чухал ололт, хүнийг төгөлдөржүүлэх хэрэгсэл гэсэн үндэслэлийг дэвшүүлсэн нь эдүгээ ч ач холбогдолтой үзэл мөн.

Мөн хүний амьдралд сургалтын ач холбогдлыг Сүнз тодорхойлж өгсөн байдаг: “Өндөрт гараагүйгээр тэнгэрийн өндрийг мэдэхгүй, газрын гүнд ороогүйгээр түүний зузааныг мэдэхгүй, их багшийн сургаалийг мэдэхгүйгээр сургалтын ач холбогдлыг мэдэхгүй” гэжээ. Цааш нь, тэрээр хэлэхдээ: “Би бүхэл өдөржингөө бодож, сэтгэсэн ч, бага хугацаанд багшаар заалгасан эрдмээс илүү ахиц гаргаж чадсангүй” хэмээн сургалтад багшийн үүргийг чухалчилсан байна.

Сүнз “Төгс хүн сурахдаа мэдлэгийг сонсголоор хүлээн авч зүрхэндээ хуримтлуулж, зүрхнээсээ биеэрээ тархааж, бие авч явах байдлаар нь илэрнэ. Ийм хүн бусад хүмүүст үлгэр дууриал болдог” хэмээн мэдлэгийг өөртөө шингээж эзэмшихийг онцлон үзжээ. Тэгвэл “Дорд хүний хувьд мэдлэг нь сонсголоор хүлээн авч хэлэн дээрээ гарч ирнэ. Өөрөөр хэлбэл, дорд хүмүүс бол сэтгэхүйгээр шууд бүх зүйлээ гарган тавих чадвар муу байдаг юм гэж үзсэн байна. Энэ тухай жишээ дурьдахад “Чихнээс хэл хүртэл дөрвөн цунь байдаг. Гэтэл хүний бие 7 чи байдаг. Тэгэхлээр 7 чи-г 4 цунь-аар яаж тодорхойлж болох вэ” хэмээн зүйрлэн хэлжээ.

Сүнз хүний хүмүүжлийн үндсэн зарчмуудыг дараах шинжээр томъёолсон байдаг. Аливаа хүн өөрийгөө муу зүйлээс, муу нөлөөнөөс ямагт хамгаалж байхаас гадна, өөрийгөө хүмүүжүүлэхдээ дараах зүйлсийг хэрэгтэй. Үүнд:

⁶¹ Р.Дарьхүү. Г.Эрдэнэбаяр. Философийн түүх. УБ., 2006. 31 дэх тал

⁶² Сүнз. Дайтахуйн ухаан. Орч. М.Чимэдцэз. УБ., 2005. 39 дэх тал

⁶³ Фэн Ю Лань. Хятадын философийн товч түүх. УБ., 2003. 132 дахь тал

“Хүний нүд нь харах ёсгүй зүйлийг харахгүй байх.
Хүний чих нь сонсох ёсгүй зүйлийг сонсохгүй байх.

Хүний хэл нь ярих ёсгүй зүйлийг ярихгүй байх.

Хүний сэтгэл зүрх нь муу зүйлийн тухай бодохгүй байх хэрэгтэй”⁶⁴.

Хүний сэтгэл зүрх нь муу зүйлийн тухай бодохгүй байх хэрэгтэй”⁶⁴.
Харин “Хүн үнэний төлөө амьдарч, үнэний төлөө үхэх ёстой”. Үүнийг л сайн үйл, ёс

журамтай гэж хэлж болно хэмээн сургасан нь орчин үед ч ач холбогдолтой юм.

Сүнзийн Аливаа хүн төрөлхөөсөө янз бүрийн хорон муу хүсэл эрмэлзэлтэй төрдөг. Тиймээс ч энэ хүслүүдээ биелүүлэхийн тулд тэмүүлдэг. Ингэж тэмүүлэх явцад хүний хүсэл тэмүүлэл хязгааргүй юм гэдгээ хүмүүс хэзээ ч мэддэггүй, харин ч биелэхгүй байх тусам түүний хойноос улайран хөөцөлдөж тэмцдэг. Энэ тэмцэл нь өрсөлдөөнийг бий болгоно, өрсөлдөөн нь элдэв янзын хямралдааныг нийгэмд үүсгэн бий болгодог. Тиймээс Хятадын өвөг дээдсүүд ийм хямралдааныг бий болгохгүйн тулд хүмүүсийг ёслол, хэм хэмжээ, нийгмийн өмнө хүлээх тодорхой үүрэг зэргийг гарган тавьсан байна. Өөрөөр хэлбэл, хүмүүс өөрсдийн хүсэл эрмэлзлэлийг хангахын тулд нийгмийн өмнө тодорхой үүрэг хүлээж, ёслол хэм хэмжээг мөрдөх ёстойг хятадын өвөг дээдсүүд тогтоож өгсөн байна хэмээн Сүнз тайлбарладаг. Үүнээс үзвэл ёс горим нь хүний хүслийг биелүүлэх явцад, түүнийг зохицуулахаар зүй ёсоор гарч ирсэн зүйл болж байна.

Аливаа юм бүхэн өөрийн хүсэлтэй байдаг. Энэ тухай Сүнз мэдрэхүйн эрхтнээр төлөөлүүлэн хэлсэн байдаг. Үүнд:

- Хамар бол сайхан, анхилуун, тааламжтай үнэр үнэрлэх дуртай.
- Нүд бол маш сайхан нарийн хийгдсэн эд зүйлс, гоё чамин хээ угалз, янз бүрийн төмрөөр хийгдсэн чамин зүйлийг харахыг хүсдэг.
- Чих бол хонхны дуу, бөмбөр гэх зэрэг хөгжмийн сайхан дуу чимээг сонсохыг хүсдэг.
- Бие бол өргөн уудам байшин, чөлөөтэй байхыг эрмэлздэг гэжээ.

Тиймээс хүн бол өөрийн хүслийг хангахад тэмүүлэх явцад юмсыг ялган үзэх болсон байна. Энэ үеэс л аливаа юмны эсрэг тэсрэг хоёр тал гарч ирэх болжээ. Жишээлбэл: “Баян ба ядуу, хөгшин ба залуу, хөрөнгөтэй ба хөрөнгөгүй” гэх мэт. Ёс горим нь эдгээр эсрэг хоёр талт зүйлсийг зохицуулах үүрэгтэй ажээ. Түүний үзлээр, ёс горим гурван зүйл дээр тулгуурлана. Үүнд: 1/ Тэнгэр газар, 2/ Өвөг дээдэс, 3/ Хаан эзэн эдгээр болно.

Цааш нь энэ гурван зүйлийн ач холбогдлыг тодорхойлохдоо: “Тэнгэр газаргүй бол хүн хаана оршин амьдрах вэ? Өвөг дээдэс байхгүй бол хүмүүс юунаас бий болох вэ? Эзэн хаан байхгүй бол дэг журмыг хэн тогтоох вэ?” гэжээ.

Сүнз ёс горимын үндсийг ёслолын үйл ажиллагаагаар баталгаажуулж өгсөн байдаг. Ёслолын үйл ажиллагааны тухай тэрээр хэлэхдээ: “Түүний гол утга учир нь тэнгэр газар, өвөг дээдэс, хаан эзнээ хүндэлж дээдлэн авч үзэх явдал байдаг. Учир нь эдгээр нь сайн сайхан зүйлийг бий болгож байдаг”⁶⁵ ажээ. Түүний үзлээр, ёслолын үйл ажиллагаа нь улиралд, сард гэсэн янз бүрийн байдлаар явагддаг. Ёслолын үйл ажиллагаа нь маш энгийн, үйл явц нь гоёмсог, төгсгөл нь баяр баясгалантай байхаас гадна хүний мэдрэхүйтэй хослож байх нь түүний гол утга учрыг илэрхийлж байна хэмээн Сүнз үздэг. Өөрөөр хэлбэл, ёслолын үйл ажиллагаа нь гол утга учраа баримтлаж чадаж байвал, эртний ёсондоо ойр байгааг

⁶⁴ Р.Дарьхүү, Г.Эрдэнэбаяр. Философийн түүх. УБ., 2006. 34 дэх тал

⁶⁵ Р.Дарьхүү, Г.Эрдэнэбаяр. Философийн түүх. УБ., 2006. 35 дахь тал

гэрчилж байна гэсэн хэрэг юм. Мөн түүнчлэн Сүнз тэмдэглэхдээ: "Ёслолын үйл ажиллагааны үед тэнгэр газар хоёр хоорондоо зөвшилцөж, нар сар хоёр маш тод гэрэлтэж, од зохицлоо олж цэцэглэнэ. Түүгээр барахгүй хайр сэтгэл, үзэн ядалт хүртэл зүг чигээ олж авдаг. Үүний үр дүнд доодос нь дуулгавартай, дээдэс нь цэцэн цэлмэг мэргэн болж, бүх юм хэвийн хэмжээнд ордог юм" гэж ёслолын үйл ажиллагааны ач холбогдлыг тодорхойлсон байдаг.

Харин энэ ёслолын үйл ажиллагаа буруу явагдвал энэ бүх үйл явдал эсрэгээр явагдана. Тийм ч учраас ёслолын үйл ажиллагаа нь бүрэн, бүх зүйл, дэг жаягаараа явах ёстой. Ёслолын үйл ажиллагааг хүндэтгэж бүрэн явуулж чадсан газарт хүмүүс аз жаргалтай байдаг. Энэ үйл ажиллагааг мөрдснөөр амьдрал, үхэл хоёрт маш анхааралтай хандах хэрэгтэй болдог. Тиймээс тэнгэрийн доорх оронд энэ системийг баримталбал улс оронд эмх цэгцтэй байдал үүсч, улс орон амгалан тайван болно. Хэрвээ ингэхгүй бол амар тайван байдал алдагдаж, улс орон эмх цэгцгүй байдалтай болж, эцэстээ сөнөх хүртэл аюулд орж болзошгүй. Тиймээс ёслолын үйл ажиллагааны зарчмыг дураараа өөрчилж хэрэгжүүлбэл сургаалын төгс байдал алдагдахад хүргэнэ. Цааш нь, Сүнз тэмдэглэхдээ: "Тэнгэр бол өндрийн дээд хэмжүүр, Газар бол юмс үзэгдлийн доод хэмжүүр, Хил хязгааргүй байдал нь өргөн уудмын дээд хэмжүүр. Төгс цэцэн хүн бол ёс суртахууны дээд хэмжүүр юм"⁶⁶ гэжээ. Иймээс ёслол, ёс заншилд хүндэтгэлтэй, ухамсартай хандах хэрэгтэй. Тиймээс ёс горимыг сахиж чадсанаараа хуулиа дээдлэх үндэс болдог ба хуулиа дээдэлснээр нийгэм үндэс суурьтай, дэг журамтай болж, төр оршин тогтнох нэг үндэс нь болж өгнө гэсэн үг.

"Төрийн хэргийг нэгтгэх"⁶⁷ гэдэг нь Сүнзийн улс төрийн гол үзэл юм. Олон улсаар аялж явахдаа энэхүү үзлээ сурталчилж, нэгдсэн Хятад улс байгуулахыг зорьж явсан байна. Олон сайд ноёдод сурталчилгаа хийж нэгдсэн хүчирхэг Хятад байгуулах үйлсэд хувь нэмрээ оруулжээ. Тэрээр аялж явсан улс орон бүртээ "Сайд түшмэл мужийн эздийг тэнгэрийн дор нэгтгэх, дөрвөн далайг нэгэн саванд цутгах" хэмээх үзлийг байнга яриж явсан гэдэг.

Сүнзийн төрийн онол товчдоо гурван үндсэн утгыг илэрхийлж байсан. Энэ нь "ёс суртахууныг хуульчлах", "чадварлаг хүний чадварыг ашиглах", "төр нь түвшин иргэн нь амгалан байх" гэсэн гурван зарчим байна. Тэр дундаа ёс суртахууныг хуульчлах нь улс төрийн онолын гол суурь гэж үзсэн. Сүнз бол Күнзийн ёс суртахууны суртлын залгамжлагч, байсан. Тэрээр газрын эзний шинэчилсэн бодлогыг гаргаж, нийгэмд шинэ бодлого дэлгэрүүлж, ёс суртахууны номлолыг түгээсэн. Боолын нийгмийн үзэл бодлыг эсэргүүцэж, хаад ноёдын үр сад ёс журмыг дагахгүй бол хэргэм зэргийг нь хасч дорд хүн болгох ёстой гэж үзэж байв.

Тэрээр ёс суртахууны зэрэгцээ хуулийг чухалчилж үздэг байсан бөгөөд энэ нь Күнзийн сургаалыг өргөжүүлэн гүнзгийрүүлсэн үзэл болно. Хэрвээ хууль үгүй ёслол байгаад, хэрэгжилт үгүй хууль байх аваас: "Шагнал нь гавъяандаа үл нийцэж

Шийтгэл нь ёсондоо үл нийцэх болно. Энэ бол самуун явдал" гэжээ. Энэ тал дээр Күнз, Сүнз хоёр адил санаатай биш байсан. Күнз нь ёслолт хуулийг онцлоод,

"Ёс суртлаар хөтөлж, ёслолоор цэгцлэвч

Эгэл ард гэмшин ичингүйрэхийн сэтгэл төрнө" хэмээснээ түүний эсрэгээр

⁶⁶ Мөн тэнд. 36 дахь тал

⁶⁷ Zhong hua ming zu jie chu ren wu chuan. Beijing. 1984. P. 135

-“тулааны үед маш хурдтай шуурга шиг довтлон орох” гэдэг нь аливаа ажил хэргийг удаашруулахгүй, шуурхай гавшгай байх нь амжилтын нэг үндэс болохыг тодорхойлсон явдал мөн. Өөрөөр хэлбэл, маргааш дараа гэж хойш тавихгүй, хурдан чанартай сайн хийх хэрэгтэй гэсэн үг юм.

-“тулаан маш хурдан, оновчтой байхаар сайтар төлөвлөгдсөн байх”⁷² нь ажлын төлөвлөгөө буюу зохион байгуулалт оновчтой сайн байх гэсэн үг бөгөөд сайн төлөвлөгөө бол нийт ажлын тавин хувьтай тэнцэнэ гэж ойлгож болно.

-“дайсны хүчийг сайн тооцох”, дайснаа дутуу үнэлж болохгүй бөгөөд “Ухаалаг жанжин нь өөрөөс хэт хүчтэй дайсантай тулахаас аль болох зайлсхийдэг бөгөөд дайсан өөрөөс хэд дахин их бол зугтна, хоёр дахин их бол ухраад салгаж тулна, адил бол ухаалаг тулна, цөөн бол довтолно, хэд дахин цөөн бол бүслэнэ”⁷³ гэх мэтчилэн дайтах урлагийн олон зарчмуудыг тодорхойлсон байна. Эдгээр зарчмууд нь өнөөгийн өрсөлдөөний нийгэмд өрсөлдөөнд хэрхэн ялж, амжилтад хүрэх арга ухаан болон өргөн хэрэглэгдэж байна. Нэг жишээ хэлэхэд, АНУ, Япон, Герман, Тайвань, Макао, зэрэг олон орны бизнесменүүд энэхүү удирдахуйн ухааны номыг ширээнийхээ ном болгож ашиглан их амжилтад хүрсэн байдаг.

Энэ бүхнээс дүгнэж үзвэл, Сүнзийн сургаалд философи, улс төр, соёл судлал, ёс зүй, дайтахуйн ухаан зэрэг олон асуудлаар чухал үзэл баримтлалуудыг боловсруулсан нь эртнээс эдүгээ хүртэл уламжлагдан ирсэн бөгөөд өнөө үед ч ач холбогдолтой хэвээр байна.

Ном зүй

- Zhong hua ming zu jie chu ren wu chuan. Beijing. 1984.
- Zhong guo zhe xue shi. Beijing. 2003
- Сүнз. Дайтахуйн ухаан. Орч. М.Чимэдцэеэ. УБ., 2005
- Фэн Ю Лань. Хятадын философийн товч түүх. УБ., 2003
- Р.Дарьхүү. Г.Эрдэнэбаяр. Философийн түүх. УБ., 2006

⁷² Мөн тэнд. 25 дахь тал

⁷³ Мөн тэнд. 29 дэх тал